



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2020 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

Г Салбар зөвлөлийн даргын үүрэгт ажлаас 7
чөлөөлж, томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3, 65.6 дахь хэсэг, Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг, “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 4.5, 5.6 дахь заалт, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөлийн даргын үүрэгт ажлаас Д.Мөрөнг чөлөөлж, тус газрын дарга Н.Ууганбаярыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 45 дугаар тогтоолд заасан хугацаанд Салбар зөвлөлийн даргаар томилсугай.

2. Төрийн албаны тухай хууль тогтоомж, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж, салбар зөвлөлийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга /Н.Ууганбаяр/-д үүрэг болгосугай.

3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албандаа алгасугай.

ДАРГА

Б.БААТАРЗОРИГ



20000678

